

ӨНДӨР УУЛНААС ЭРЭН ХАЙХ, АВРАХ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмыг өндөр уулын бүсэд аюулт үзэгдэл, ослын үед эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулахад төв, орон нутгийн Онцгой байдлын анги, байгууллага дагаж мөрдөнө.

Хоёр. Нэр, томъёоны тодорхойлолт

2.1. Энэ журманд хэрэглэсэн “MNS 6352:2012 Уулын аврах ажиллагааны хувцас, хэрэглэлд тавих шаардлага”, “MNS 6010:2016 Гамшгийн холбогдолтой нэр томъёо”, “ОББС0001:2018 Эрэн хайх, аврах ажиллагааны стандарт”-д зааснаас бусад нэр, томъёог дараах байдлаар ойлгоно. Үүнд:

2.1.1. “Аврагч-уулчны мэргэжлийн үнэмлэх” гэж өндөр уулнаас эрэн хайх, аврах ажиллагааг гүйцэтгэхэд бэлтгэгдсэн эрх бүхий алба хаагчдад олгосон баримт бичгийг;

2.1.2. “Аврагч-уулчны мэргэжлийн зэрэг” гэж өндөр уулнаас эрэн хайх, аврах ажиллагааг гүйцэтгэхэд бэлтгэгдсэн эрх бүхий алба хаагчдын мэргэжлийн түвшинг;

2.1.3. “Аврагч-уулчны нэгдсэн бүртгэл” гэж өндөр уулнаас эрэн хайх, аврах ажиллагааболон сургалт, дадлагынсудалгааг;

2.1.4. “Авиралтын бүдүүвч, маршрут” гэж өндөр уулнаас эрэн хайх, аврах ажиллагааны авиралтыг баталсан чиглэлийг;

2.1.5. “Амьд гарах арга” гэж янз бүрийн нөхцөл байдалд хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн арга хэмжээг;

2.1.6. “Агуйнаас эрэн хайх, аврах ажиллагаа” гэж агуйд эрэн хайх, аврах ажиллагааг тусгай технологийн дагуу гүйцэтгэх ажиллагааг;

2.1.7. “Өндөр уулнаас эрэн хайх, аврах ажиллагаа” гэж өндөр уулын бүсэд цасан нуранги, мөс, хад, ангал, хавцлаас эрэн хайх, аврах ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалттай тусгай технологийн дагуу гүйцэтгэх ажиллагааг;

2.1.8. “Өндөр уулын бүс” гэж далайн түвшнээс 2500 метрийн өндөр болон авиралт хийхэд хүндрэл бүхий уулсыг;

2.1.9. “Уулнаас эрэн хайх, аврах ажиллагааны зааварлагч” гэж өндөр уулнаас эрэн хайх, аврах ажиллагааны удирдлага, зохион байгуулалт болон сургалтын технологи эзэмшсэн, уулын спортынзэрэгтэй алба хаагчийг;

2.1.10. “Уулын өвчин” гэж агаар мандал дахь хүчилтөрөгчийн зохист даралт буурснаас бие махбодид үүсэх өөрчлөлтийг;

2.1.11. “Ууланд гаралт” гэж тусгай хэрэгсэл ашиглахгүй ууланд гарах ажиллагааг;

2.1.12. “Ууланд авиралт” гэж тусгай хэрэгсэл ашиглан өндөр уулынбүсэдтехникийн авиралтыг;

2.1.13. “Ууланд дайралт” гэж тусгай хэрэгсэл ашиглан өндөр уулынбүсэдбүдүүвч, маршрутын дагуу техникийн аврах ажиллагааг;

2.1.14. “Ууланд осолдох” гэж хүн болон мал амьтан, тээврийн хэрэгсэл өндөр уулын бүсэд осолдохыг;

2.1.15. “Хамгаалалтын бэхэлгээний цэг” гэж хөдөлгөөнгүй болон суурийг зохиомлоор үүсгэсэн эсхүл аливаа тогтоцыг ашиглан бат бөх, даах

чадварыг тооцсон цэгийг;

Гурав. Өндөр уулнаас эрэн хайх, аврах ажиллагааны үе шат

3.1. Мэдээлэл хүлээн авах. Үүнд:

3.1.1. дуудлагын талаарх товч мэдээлэл;

3.1.2. буцаад холбоо тогтоох /мэдээлэл өгөгчийн нэр, хаяг, утасны дугаар/;

3.1.3. ослын талаарх мэдээлэл /байршил, эхэлсэн огноо, цаг, минут/;

3.1.4. ослын газарт хүрэлцэн очих зам, маршрут;

3.1.5. нэрвэгдэгсдийн эрүүл мэндийн байдал;

3.2. Мэдээллийг хүлээн авсан төв, орон нутгийн Онцгой байдлын анги, байгууллага нь дараах ажиллагааг явуулна. Үүнд:

3.2.1. мэдээллийг нягтлан шалгах;

3.2.2. мэдээллийн дагуу байр зүйн зураг дээр тэмдэглэх;

3.2.3. шаардлагатай мэдээллийг цуглуулах;

3.2.4. ослын үеийн болзошгүй /2-оос илүү/ хувилбарыг таамаглах;

3.2.5. эрэн хайх, аврах нэгжийг томилох;

3.2.6. хайлтын бүсийг тогтоох;

3.2.7. эрэн хайх, аврах ажиллагааны бүх мэдээллийг нэгтгэн дүгнэх.

3.3. Голомтод хүрэлцэн очих. Үүнд:

3.3.1. ослын голомт руу хөдөлгөөн үйлдэх;

3.3.2. ослын голомт руу шуурхай хүрэлцэн очих зам, маршрутыг тогтоох;

3.3.3. нөөц зам, маршрутын хувилбарыг тооцох;

3.3.4. байр зүйн зураг болон байршил тогтоогч /GPS/-д тэмдэглэх;

3.3.5. болзошгүй нөхцлийг тооцох;

3.3.6. дээд шатны байгууллагад мэдээллийг тогтмол дамжуулах, хүлээн авах.

3.4. Төлөвлөх /цагийн байдлыг үнэлж шийдвэр гаргах/. Үүнд:

3.4.1. хээрийн штабыг байгуулах;

3.4.2. шаардлагатай нэмэлт хүч, хангалтын тооцоог хийх;

3.4.3. шаардлагатай тохиолдолд сайн дурынхныг эрэн хайх, аврах ажиллагаанд татан оролцуулах;

3.4.4. эрэн хайх, аврах ажиллагаанд оролцогчдод үүрэг даалгавар, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх.

3.5. Шуурхай арга хэмжээг авах. Үүнд:

3.5.1. голомтын бүс орчмын байгаль, цаг агаарын нарийвчилсан мэдээг авах;

3.5.2. голомтын бүсэд аврагчдыг томилгоожуулах;

3.5.3. бүлэг, аврагч нарт даалгаврыг өгөх;

3.5.4. ажиллагааны бүрэлдэхүүний бүтцийн бүдүүвчийг гаргах;

3.5.5. байр зүйн /даргын ажлын/ зураг хөтлөх;

3.5.6. ажиллагааны тэмдэглэл хөтлөх.

3.5.7. нэрвэгдэгсдийг хүлээн авах, тээвэрлэх ажиллагааг зохион байгуулах.

3.6. Ажиллагааг дуусгах. Үүнд:

3.6.1. гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын иргэдийн эрэн хайх, аврах ажиллагааны хүч хэрэгслийн бүртгэл, жагсаалтыг гаргасан байх;

3.6.2. нэрвэгдэгсэд болон буцалтгүй нэрвэгдэгсдийн талаарх мэдээллийг нэгтгэсэн байх;

3.6.3. ашигласан техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн зардлын

тооцоог гаргасан байх;

3.6.4. эрэн хайх, аврах ажиллагаанд оролцогчдын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг ачаалан бэлтгэж тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган голомтоос байнгын байрлал руу хөдөлгөөн үйлдэх;

3.6.5. энэ журмын 3.6.1-т заасан жагсаалтын дагуу эрэн хайх, аврах ажиллагааны даалгавар, илтгэх хуудас, тайлан, нотломж, бүдүүвч зургийг бүрдүүлсэн байх;

3.6.6. дараагийн ажиллагааны бэлэн байдлыг хангасан талаарх мэдээллийг харьяа холбогдох байгууллагад мэдэгдэх.

Дөрөв. Өндөр уулнаас эрэн хайх, аврах ажиллагааны удирдлага /албан тушаалтан/-ын чиг үүрэг

4.1. Өндөр уулнаас эрэн хайх, аврах ажиллагаагцар, хүрээ, аюулын зэргээс нь хамаарч улс, бүсийн болон орон нутгийн түвшинд зохион байгуулна.

4.2. Эрэн хайх, аврах ажиллагааны ерөнхий удирдагч нь “ОББС 0001:2018 Эрэн хайх, аврах ажиллагааны стандарт”-ын 7.1-т заасан чиг үүргээс гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.2.1. хээрийн штаб байгуулах;

4.2.2. голомтын бүсийг тогтоох;

4.2.3. ажиллагааны даалгавар танилцуулж, бие бүрэлдэхүүнд үүрэг, чиглэл өгөх;

4.2.4. шаардлагатай хүч хэрэгслийг нэмэгдүүлэх, татан байршуулах, нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг зохион байгуулах;

4.2.5. эрэн хайх, аврах ажиллагаанд зарцуулах, хүнс, шатахууны нөөцийг бүрдүүлэх;

4.2.6. харьяа дээд шатны удирдлагыг мэдээллээр хангах;

4.3. Эрэн хайх, аврах ажиллагааны ахлах удирдагч нь “ОББС 0001:2018 Эрэн хайх, аврах ажиллагааны стандарт”-ын 7.2-т заасан чиг үүргээс гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.3.1. үүрэг гүйцэтгэх бүлгүүдийг голомтын бүсэд хуваарилах;

4.3.2. улс, орон нутгийн гамшгаас хамгаалах алба, ерөнхий болон тусгай мэргэжлийн ангийн ажиллах ээлж, хуваарь, амрах цагийг тогтоож, холбогдох үүрэг чиглэл өгөх;

4.3.3. эрэн хайх, аврах ажиллагааны даалгаврын баримт бичгийн бүртгэл хөтлөх, голомтын бүсэд байр зүйн /оператив-тактик/ зураг дээр ажиллах, тэмдэглэх;

4.3.4. байгаль, цаг агаар, үүссэн нөхцөл байдлыг харгалзан эрэн хайх, аврах ажиллагааны үргэлжлэх хугацааг эрэн хайх, аврах ажиллагааны ерөнхий удирдагчтай зөвшилцөж тогтоох;

4.4. Эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч нь “ОББС 0001:2018 Эрэн хайх, аврах ажиллагааны стандарт”-ын 7.3-т заасан чиг үүргээс гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.4.1. энэ журмын 3.3, 3.4, 3.5, 3.6-д заасан ажиллагааны эхний арга хэмжээг мэргэжлийн дагуу шуурхай хэрэгжүүлэх;

4.4.2. эрэн хайх, аврах ажиллагааны даалгаврын баримт бичгийн бүртгэл хөтлөх, голомтын бүсэд байр зүйн /тактик/ зураг дээр ажиллах, тэмдэглэх;

4.4.3. хүч нэмэгдүүлэх саналыг харьяа онцгой байдлын байгууллагад гаргах;

4.4.4. аврагчдыг томилгоожуулж, аюулгүй байдалд хяналт /2 дугаар хавсралтад заасны дагуу/ тавьж, удирдан зохион байгуулах;

4.4.5. учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

4.4.6. ууланд авиралт, дайралт хийх үед холбооны хэрэгслээс гадна нэмэлт мэдээллийн гар дохиог өгөх /гар чийдэн, дарцаг, биеийн хөдөлгөөний гэх мэт/, харилцах дохиог тогтоох;

4.4.7. нэрвэгдэгсдийн байгаа газар, тэдгээрийн тоо, богино хугацаанд очих зам, чиглэл, биеийн байдал, хоёрдогч аюултай хүчин зүйлс байгаа эсэхийг тодруулах;

4.4.8. эрэн хайх, аврах ажиллагаа эхэлснээс хойш 72 цагийн дотор төөрсөн, сураггүй болсон иргэнийг олоогүй тохиолдолд ар гэрийнхэн болон эрэн хайх, аврах ажиллагааны ахлах удирдагчтай зөвшилцөн үргэлжлүүлэх, хойшлуулах эсхүл зогсоох шийдвэр гаргах.

4.5. Уулнаас эрэн хайх, аврах ажиллагааны зааварлагч нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.5.1. бие бүрэлдэхүүнд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх;

4.5.2. өндөрт ажиллах үеийн хамгаалах бэхэлгээний цэгийг тогтоох, техникийн авиралт, аврах ажиллагааны зааварчилгааг өгөх;

4.5.3. аврагч-уулчны холбогдох бичиг баримт /11, 12 дугаар хавсралтад заасны дагуу/-д тэмдэглэл хийх.

4.6. Эрэн хайх, аврах ажиллагааны эмч /аврагч-эмнэлгийн зааварлагч/ нь “Эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах нийтлэг журам”-ын 4.3-т заасан чиг үүргээс гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.6.1. бие бүрэлдэхүүнд /10 дугаар хавсралтад заасны дагуу/ уулын өвчнөөс сэргийлэх талаарх зөвлөгөөг өгөх;

4.6.2. нэрвэгдэгсдэд шуурхай тусламж үзүүлэх анхны тусламжийн цэгийг байгуулах;

4.6.3. аврагч-уулчин нарт нэрвэгдэгсдэд үзүүлэх анхны тусламжийн талаарх зааварчилгааг өгөх;

4.6.4. шаардлагатай тохиолдолд аврагчийг эрүүл мэндийн шалтгаанаар ажиллагаанаас чөлөөлөх;

4.6.5. аврагч-уулчны холбогдох бичиг баримт /11 дүгээр хавсралтад заасны дагуу/-д тэмдэглэл хийх.

4.7. аврагч-уулчин нь “ОББС 0001:2018 Эрэн хайх, аврах ажиллагааны стандарт”-ын 7.4-д заасан чиг үүргээс гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.7.1. нэгдүгээр аврагч:

4.7.1.1. аврагч-уулчны иж бүрдлээс тухайн ажиллагаанд тохирох хөнгөн хэрэгслийг сонгож хоёр, гурав, дөрөвдүгээр аврагч бэлэн болсон үед аврах олсыг өөрт бэхлэж авирах;

4.7.1.2. авиралтын бүдүүвч, маршрут, төлөвлөгөөний дагуу урьдчилан тодорхойлсон аюулгүй цэгт бэхэлгээг хийж хоёрдугаар аврагчийг хамгаалан өөрийн байрлалд ирэх үед дараагийн аврилтыг бие даан гүйцэтгэх;

4.7.1.3. нэрвэгдэгсдэд анхны тусламж үзүүлэх.

4.7.2. хоёрдугаар аврагч:

4.7.2.1. нэгдүгээр аврагчийн байрлалд ирсэн үед түүний бэхэлсэн цэгээс болон өөр давхар хамгаалах бэхэлгээний цэгийг хийх;

4.7.2.2. нэгдүгээр аврагчийг цааш авирахад хамгаалах;

4.7.2.3. давхар хамгаалах бэхэлгээний цэгээс гуравдугаар аврагчийг эсхүл нэрвэгдэгсдийг болон ачааг татах ажиллагааг гүйцэтгэх;

4.7.3. гуравдугаар аврагч:

4.7.3.1. хоёрдугаар аврагчийн байрлалд очих эсхүл түүнд нэрвэгдэгсэд болон ачааг дамжуулах үеийн доод талаас савах, байрлалыг өөрчлөх зэргээр туслан хамгаалах;

4.7.3.2. хоёрдугаар аврагчаар хамгаалуулан түүний байрлалд очих;

4.7.3.3. хоёрдугаар аврагчийг цааш авирах үед хамгаалах;

4.7.3.4. давхар хамгаалах бэхэлгээний цэгээс дөрөвдүгээр аврагчийг эсхүл нэрвэгдэгсдийг болон ачааг татах;

4.7.3.5. нэрвэгдэгсэд болон ачааг хамгаалах.

4.7.4. дөрөвдүгээр аврагч:

4.7.4.1. гуравдугаар аврагчаар хамгаалуулан түүний байрлалд очих;

4.7.4.2. гуравдугаар аврагчийг цааш авирахад хамгаалах;

4.7.4.3. давхар хамгаалах бэхэлгээний цэгээс гуравдугаар аврагчийг эсхүл нэрвэгдэгсдийг болон ачааг татах;

4.7.4.4. нэрвэгдэгсэд болон ачааг хамгаалах;

4.7.4.5. нэг, хоёр, гуравдугаар аврагчийн техникийн аврах ажиллагааны зааварчилгааг өгөх, хяналт тавих.

4.7.5. аврагч-уулчид онцгой нөхцөл байдалд өөрсдийн болон бусдын амь нас, эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх чадвартай байх;

4.7.6. аврагч-уулчид холбогдох /6, 7, 8, 9, 11, 12 дугаар хавсралтад заасны дагуу/ зааварчилгаагаар ажиллах.

Тав. Өндөр уулнаас эрэн хайх, аврах ажиллагааны хэлбэр

5. Өндөр уулнаас эрэн хайх, аврах ажиллагааг газраар, агаараар гэсэн хоёр хэлбэрээр зохион байгуулахдаа орон нутгийн элементээр, талбайг хувааж квадратаар, самнах аргыг сонгоно. Үүнд:

5.1. Газраар хайх /өндөр уулын цас, мөс, хад, ангал, хавцал, агуй, говь, цөл, ой, тайгад/ хэлбэр:

5.1.1. цас, шавар дээр хайж буй хүний мөр олсон тохиолдолд нэгдүгээр аврагчийг үндсэн мөрөөр, зэрэгцээ баруун талд хоёрдугаар аврагч, зүүн талаар гуравдугаар аврагчийг дагуулж явуулах бөгөөд хайж буй хүн зам, чиглэлээ өөрчилсөн даруйд илрүүлэх боломжтой хувилбараар явах;

5.1.2. хайж буй хүний мөр, эд зүйлс олдсон тохиолдолд түүнийг зөвхөн нэг аврагч /нохой хөтлөгч/ авч баримтжуулах буюу цагдаагийн алба хаагчид хүлээлгэх өгөх;

5.1.3. газраар эрэн хайх ажиллагааг гинжин хэлбэрээр 20 метр тутамд нэг аврагч байхаар тооцож 2 км-ээс ихгүй зайд самнах;

5.1.4. хэрэв газрын гадарга нь бартаатай тохиолдолд хайлтын өргөн 500-1000 метр байх;

5.1.5. нэг аврагч 1-2 км² талбайг 4 цагийн хугацаанд самнах;

5.1.6. шаардлагатай тохиолдолд эрэн хайх, аврах ажиллагаанд эрэлч нохой ашиглаж болно.

5.2. Агаарын хөлөг болон төрөл бүрийн нисэх төхөөрөмж ашиглан агаараас эрэн хайх хэлбэр:

5.2.1. бартаа, саад ихтэй алслагдсан уулархаг бүсэд агаарын хөлөг, нисгэгчгүй нисэх төхөөрөмж зэргийг ашиглах;

5.2.2. майхан, эд зүйлс, хувцас зэргийг үлдээсэн эсэхийг агаараас илрүүлэх;

5.2.3. агаараас эрэн хайх /4 дүгээр хавсралтад заасны дагуу/ тохирох аргыг сонгох.

Зургаа. Өндөр уулын цасан нурангинаас эрэн хайх, аврах ажиллагаа

6.1. Энэ журмын 4.7.1-4.7.4-т заасан тоот томилгоогоор ууланд авирах, дайралтын үеийн ажиллагааг /2 дугаар хавсралтад заасны дагуу/ гүйцэтгэх;

6.2. Ажиллагааны удирдагчийн шийдвэрээр гинжинд тарж цасны тэмтрүүлээр хатгах үйлдлийг гүйцэтгэх;

6.3. үүссэн цагийн байдлыг /хэдэн хүн байсан, ямар тэмдэг байгаа эсэх/ үнэлэх;

6.4. өөрсдийн хүч хэрэгслийг мэдээлэх;

6.5. нүдэн ажиглалтаар нэрвэгдэгсдийн байршлыг тодорхойлох;

6.6. хоёрдогч нуранги үүсэх магадлалтай эсэх, эрэн хайх газар аюултай эсэхийг үнэлэх;

6.7. эрэн хайх, аврах нэгжийн аврагчийн тоо, нэрвэгдэгсдийн тоо, цасан нурангийн хэмжээний харьцааг тодорхойлох;

6.8. нэрвэгдэгсдийн хамгийн сүүлийн харагдсан газрыг тэмдэглэх /хэрэв боломжтой бол/;

6.9. таамаглан хайх;

6.10. хэсэгчилж хайх /3х3 метрийн хэмжээтэй/;

6.11. тэмтрүүлээр хайх /20-25 см-ын зайтайгаар цасны тэмтрүүл ашиглаж хатгах/;

6.12. цасан нуранги ухаж хайх;

6.13. байршил тогтоогч багаж хэрэгсэл ашиглах;

6.13. нэрвэгдэгсдэд анхны тусламж үзүүлэх;

6.14. нэрвэгдэгсдийг тээвэрлэх ажиллагааг зохион байгуулах.

Долоо. Өндөр уулын мөсөнд эрэн хайх, аврах ажиллагаа

7.1. Энэ журмын 4.7.1-4.7.4-д заасан тоот томилгоогоор ууланд авирах, дайралтын үеийн ажиллагааг /2 дугаар хавсралтад заасны дагуу/ гүйцэтгэх;

7.2. Өндөр уулын мөсөнд авиралтын багаж, хэрэгслийг тохируулан бэлтгэх;

7.3. Авиралтын хамгаалалтын бэхэлгээний цэгийг төлөвлөх;

7.4. Хамгаалалт бэхэлгээг техникийн дагуу гүйцэтгэх;

7.5. Авиралтын хоорондын хамгаалалтын олсны хэмжээг тооцох;

7.6. Техникийн дагуу авирах;

7.7. Өндөр уулын мөсөнд авирах, мөсөн гол гатлах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг баримтлах;

7.8. Нэрвэгдэгсдэд анхны тусламж үзүүлэх;

7.9. Нэрвэгдэгсдийг тээвэрлэх ажиллагааг зохион байгуулах.

Найм. Өндөр уулын хад, ангал, хавцлаас эрэн хайх, аврах ажиллагаа

8.1. Энэ журмын 4.7.1-4.7.4-д заасан тоот томилгоогоор ууланд авирах, дайралтын үеийн ажиллагааг /2 дугаар хавсралтад заасны дагуу/ гүйцэтгэх;

8.2. Дөрөвдүгээр аврагчийн зааварчилгаагаар өндөр уулын хад, ангал, хавцал руу буулгах, татах үеийн хамгаалалтын бэхэлгээний үндсэн болон нөөц цэгийг нэгээс гуравдугаар аврагчид гүйцэтгэх;

8.3. Нэг, хоёр, гуравдугаар аврагчид өндөр уулын хад, ангал, хавцал руу буулгах, татах системийг угсрах;

8.4. Дөрөвдүгээр аврагчийн зааварчилгаагаар хоёр, гуравдугаар аврагч өндөр уулын хад, ангал, хавцал руу нэгдүгээр аврагчийг буулгаж мэдээлэл цуглуулах;

8.5. Нэгдүгээр аврагч нэрвэгдэгсдэд анхны тусламжийг үзүүлэх;

8.6. Нэгээс дөрөвдүгээр аврагч шаардлагатай тохиолдолд аврагч-эмнэлгийн зааварлагчийг нэрвэгдэгсдэд хүргэх ажиллагааг зохион байгуулах;

8.7. Дөрөвдүгээр аврагч нь нэгдүгээр аврагчийн өгсөн мэдээллийн дагуу аврах ажиллагааны удирдагчид цагийн байдлыг илтгэж, удирдагчийн шийдвэрээр ажиллагааг гүйцэтгэх;

8.8. Нэрвэгдэгсдийг өндөр уулын хад, ангал, хавцлаас буулгах, татах ажиллагааг гүйцэтгэсний дараах тээвэрлэх ажиллагааг аврах ажиллагааны удирдагчийн шийдвэрээр зохион байгуулна.

Ес. Агуйнаас эрэн хайх, аврах ажиллагаа

9.1. Агуйнаас эрэн хайх, аврах ажиллагааг гүйцэтгэх бүлэг, аврагч нар /3 дугаар хавсралтад заасны дагуу/ аюулгүй ажиллагааны зааварчилгааг удирдлага болгох;

9.2. Агуйны гүнийг тогтоох;

9.3. Агуйн амны байдлаас шалтгаалан гурван хөлт тулгуур ашиглан хамгаалах бэхэлгээг хийх;

9.4. Агуйд орохдоо нэгдүгээр аврагч ганцаараа бууж агуйн ёроол буюу тэгш газар буусны дараа хоёрдугаар аврагчийг оруулах;

9.5. Энэ журмын 9.4-т заасан аврагчид эхний тандалт /метан, ус, агуйны шинж чанар, нэрвэгдэгсдийн байршил, эрүүл мэндийн байдал/-ыг аврах ажиллагааны удирдагчид мэдээлэх;

9.6. Энэ журмын 9.5-д заасан ажиллагааг хийсний дараа гурав, дөрөвдүгээр аврагч шаардлагатай багаж хэрэгслийг авч нэг, хоёрдугаар аврагчид дэмжлэг үзүүлэх, нэрвэгдэгсдийг татан гаргах ажиллагааг гүйцэтгэх;

9.7. Агуйн ам жижиг, өрх хэлбэрийн амтай, харьцангуй гүн багатай тохиолдолд гурван хөлт тулгуурыг ашиглах бөгөөд агуйн ам орчимд нуралт үүсэхээр бол ашиглахыг хориглох;

9.8. Том амтай агуйд хамгаалалтын олсыг үндсэн чулуунд өрөмдөж 2-оос доошгүй бэхэлгээ хийж бэртэж, гэмтсэн хүнийг ролик, агуйн дамнуурга ашиглан татаж гаргах;

9.9. Аврах олсыг хаданд үрэгдэхээс хамгаалсан үндсэн олсны хамгаалалтыг шаардлагатай газруудад хийх, туслах олс, агуйн эвхдэг шатыг ашиглах;

9.10. Агуйн гүнээс нэрвэгдэгсдийг татаж гаргахдаа аврах олсны даац, багаж төхөөрөмжийн найдвартай байдлыг тооцоолох;

9.11. Агуйн хана, дээврийн нуралтаас болгоомжилж хүрч хөндөхгүйгээр буух, гарах, олон салаа агуйд төөрөхөөс хамгаалж замын тэмдэглэгээний утас татах;

9.12. Агуйнаас нэрвэгдэгсдийг татан гаргах ажиллагааны төлөвлөгөө зам, гарцын чиглэлийн тэмдэг, тэмдэглэгээг өнгөөр тэмдэглэх.

Арав. Хөдөлмөр хамгаалал, аюулгүйн ажиллагаа, мэргэжлийн сургалт, дадлага

10.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм

10.1.1. “Онцгой байдлын байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм”-ийн дагуу төв, орон нутгийн онцгой байдлын анги, байгууллагын хөдөлмөр, хамгаалал, аюулгүй ажиллагаа хариуцсан

мэргэжилтэн болон эрэн хайх, аврах ажиллагааны зааварлагч хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана;

10.1.2. өндөр уулнаас эрэн хайх, аврах ажиллагааны холбогдох дүрэм, журам, заавар, стандартын хэрэгжилтийг эрэн хайх, аврах нэгжийн захирагч, бүлэгт бүлгийн дарга хэрэгжүүлнэ;

10.2. Мэргэжлийн сургалт, дадлага

10.2.1. өндөр уулнаас эрэн хайх, аврах ажиллагааны тусгай бэлтгэл, мэргэжил олгох сургалтыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцан зохион байгуулна;

10.2.2. өндөр уулнаас эрэн хайх, аврах ажиллагааны дадлагыг төв, орон нутгийн Онцгой байдлын анги, байгууллага зохион байгуулна;

10.2.3. аврагч-уулчны мэргэжлийн баримт бичиг, нэгдсэн бүртгэл, судалгааг өндөр уулнаас эрэн хайх, аврах ажиллагааны зааварлагч эсхүл эрх бүхий мэргэжилтэн хариуцах;

10.2.4. өндөр уулнаас эрэн хайх, аврах ажиллагааны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, нормативыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батлана.

10.2.5. энэ журмын 2.1.2-т заасан “Аврагч-уулчны мэргэжлийн зэрэг” нь “анхан” буюу “дөрөв”, “дунд” буюу “гурав”, “дээд” буюу “хоёр”, “гүнзгий” буюу “нэгдүгээр” гэх шатлалтай бөгөөд түүнд олгох мэргэшлийн зэргийн нэмэгдлийг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2019 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/111 дүгээр тушаалаар батлагдсан “Онцгой байдлын байгууллагын алба хаагчид олгох мэргэшлийн зэргийн шалгуур үзүүлэлт”-ийн дагуу олгож болно.

Арваннэг. Хяналт, хариуцлага

11.1. “Өндөр уулнаас эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах журам”-ын хэрэгжилтэд гамшгийн шуурхай удирдлага болон захиргааны удирдлага хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга нар хяналт тавина.

11.2. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хэрэгжилтэд төв, орон нутгийн онцгой байдлын анги, байгууллагын дарга, захирагч нар хяналт тавина.

11.3. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

ӨНДӨР УУЛЫН ЦАС, МӨС, ХАД, АНГАЛ, ХАВЦЛААС ЭРЭН ХАЙХ, АВРАХ
АЖИЛЛАГААНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР

1. Өндөр, уулархаг газар явуулах эрэн хайх, аврах ажиллагааны аюулгүй байдалд нөлөөлдөг үндсэн /уулын хотгор, гүдгэр, 2500 м-ээс дээш өндөр дэх агаарын сийрэгжилт, агаарын хэмийн эрс өөрчлөлт, хүчтэй салхи, хэт ягаан туяаны илүүдэл, үүлэрхэг, хүнс, усны хэрэглээний хязгаарлагдмал байдал, цас болон чулууны нуранги, мөсөн гол, ангал, хавцал, агуй гэх мэт/ хүчин зүйлсийг урьдчилан тооцох;
2. Эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч /бүлгийн дарга/-ийн шийдвэрээр тогтоосон ууланд гаралт, авиралт, дайралтыг гүйцэтгэх дарааллыг өөрчлөхийг хориглох;
3. Өндөр ууланд авиралт, дайралтын үед ашиглах системийг угсарч бэлэн болгосны дараа ажиллагааг эхлэх;
4. Авиралтын бүдүүвч, маршрут, төлөвлөгөөний дагуу тоног хэрэгслийг нэг, хоёр, гурав, дөрөвдүгээр аврагчид дарааллаар хүндийн жинг тохируулан бэлтгэх;
5. Аврагч-уулчин ууланд гаралт, авиралт, дайралт гүйцэтгэхдээ хувийн уулын хэрэгсэл, олсны бүрэн бүтэн байдлыг шалгаж, бэлтгэсэн байх;
6. Аврах олсыг шалгахдаа нэг үзүүрээс эхлэж нөгөө тал хүртэл нугалах, татах зэргээр сэмэрсэн, язарсан, гадна харагдах хэсэг нь бүтэн боловч дотроо тасарсан, тасарч болзошгүй эсэхийг шалгах;
7. Уулнаас эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч болон зааварлагч ньаврах олсыг ажиллагаанд болон дууссаны дараа хүлээлгэн өгөхдөө хадгалалт, ашиглалтын тогтоосон үзлэгээр давхар шалгах;
8. Уулнаас эрэн хайх, аврах ажиллагаанд эмийн сан, холбоо, дохионы болон бусад шаардлагатай багаж хэрэгслийг бэлтгэсэн байх;
9. Тухайн газар орон болон гаралт, авиралт, дайралт гүйцэтгэх уул болон цаг агаарын талаарх мэдээллийг авсан байх;
10. Аврагч-уулчид ууланд гаралт, авиралт, дайралтыг техникийн дагуу гүйцэтгэх;
11. Ууланд гаралт, авиралт, дайралтын үед хоёр аврагч-уулчны олс хоорондын зай гаралт болон авиралт 10-15 м, мөсөн голоор 15-30 м, дайралтын үед 6-7 м байхаар 3-5 аврагч нэг хамгаалалтын олсонд орох;
12. Туршлагатай аврагч-уулчин, хөтөч, газарчныг чиглүүлэгчээр томилох;
13. “Нэг жим” буюу замаар мөр дагаж алхах, амрах, зогсохдоо нэг заавраар байх;
14. Ууланд гаралт, авиралт, дайралт гүйцэтгэж байгаа үед асга хад, цас нурах үед бусдад дохио өгч мэдээлэх;
15. Ууланд гаралт, авиралт, дайралт гүйцэтгэж байгаа үед шинэ цастай газраар явахдаа цасны доор ан, цав, ангал байж болзошгүйг анхаарах;
16. Аврагч-уулчид нэрвэгдэгсдийг өндөр уулнаас тээвэрлэн буулгаж байгаа үед үндсэн олс болон хамгаалах олсыг бэхэлсэн байх;
17. Ууланд гаралт, авиралт, дайралтын үед хад, асга цуулах, дуу чимээ үүсгэх, ан амьтан үргээх, мод, ургамал таслах, хог хаягдал, гал асааж орхих зэрэг үйлдлийг хориглох;
18. Эрэн хайх, аврах ажиллагаа явуулах үед аврагчид уулын янз бүрийн гадаргаар явах шаардлагыг тооцох;

19. Удаан хугацаагаар явах, газар орны төвөгтэй хэсгийг туулах үед хүчээ гамнах, жигд амьсгалах ба хөдөлгөөний дэглэмийг баримтлах;
20. Байнгын ачаалал ихтэй үед жигд /өгсүүр замыг туулах үед зүүн хөлөө тавихдаа амьсгал авч, баруун хөлөө тавихдаа амьсгалаа гаргах/ амьсгалах;
21. Удаан хугацаанд ачаалалтай ажиллах үед бие организм эцэж, цуцахаас урьдчилан сэргийлэхийн тулд хамраараа амьсгалах;
22. Алхах үедээ хөлөө хөндлөн тавьж, бүтэн улаараа гишгэх;
23. 35 градусын налуутай, өвс ихтэй газраар шууд дээш өгсөх үедээ өлмий дээрээ алхах ба дунд зэргийн налуутай жимгүй үед туузан хэлбэрээр /ташуулдаж/ явах бөгөөд нойтон, өндөр өвстэй, налуу газраар шавар, шороон хөрстэй хэсгүүдэд анхааралтай явах;
24. Өвс ихтэй налуу газраар өгсөхдөө гутлын ул өвстэй бүтэн наалдаж байхаар хөлөө тавьж явах;
25. Уруудах үедээ хөлөө шулуун урагш нь тавьж, аль болох бүтэн улаараа гишгэн хөлөөрөө бага зэрэг нугалж явах;
26. Бамбалзуур эгц налуугаар уруудахад гутлын өсгийг газарт сайн шигтгэж явах;
27. Эгц налуу газраар хурдан буухдаа ойр, ойрхон алхаж явах;
28. Өгсөх, уруудахдаа биеийн хүндийн төвийг уулын налуугаас хол байлгах;
29. Асга нурангитай газраар явахад чулуу нурах, нурал үүсэх аюулыг тооцох;
30. Жижиг чулуунаас бүрдсэн асгатай газраар буухдаа тэдгээртэй хамтгулсан буух үед болзошгүй их хэмжээний нурал үүсгэхээс сэргийлэх;
31. Их хэмжээний хад, чулуу нурж эхэлвэл хажуу тийш яаралтай гарч өөр асган дээр очих;
32. Том чулууг тогтоож чадаагүй болон унаж байгаа чулууг харсан нь бүгдэд сонсогдохоор “Чулуу” гэж чангаараа хашгирч мэдэгдэх;
33. Дээрээс өнхрөн ирж буй чулуунаас хажуу тийш болох эсхүл доош тонгойх;
34. Хад, чулуу их хэмжээгээр нуран унаж буй тохиолдолд ойролцоох цохио эсхүл том хадны ард нуугдах;
35. Ил газар жижиг чулууны нуралтаас үүргэвчээ толгой дээрээ өргөж хамгаалах;
36. Тогтвортой хад, асгатай газраар явахдаа эгц дээш буюу аюул багатай газрыг сонгож бага зэрэг мурилзаж явах;
37. Уруудахдаа ташуулдаж эсхүл эгц доошоо явах;
38. Асга, нурангитай газар доор явж байгаа хүнийг гэмтээхгүйн тулд газраар ташуулдаж буух;
39. Хэрэв ташуулдан бууж болохгүй тохиолдолд хөлөөрөө эгц дээш босон бие биетэйгээ аль болох ойрхон явах;
40. Биеийн хүндийн жинг хөлдөө төвлөрүүлэхийн өмнө асган дээр бүрэн гишгэж явах;
41. Хад, цохиогоор явахдаа дараах зааврыг баримтлах. Үүнд:
 - 41.1. Хад чулуутай хэсгээр явахдаа хамгаалалтын дуулга, бээлий өмсөх;
 - 41.2. Явах маршрутаа харж тэмдэглэх;
 - 41.3. Гар, хөлөөрөө төвгөр хэсэгт барьц авхаас өмнө түүний бат бөх эсэхийг шалгах;
 - 41.4. Нэг хөлөө зөөж газар тавихын өмнө нөгөө хөл ба хоёр гараараа сайн тулах;
 - 41.5. Хүндрэлтэй тохиолдолд хаднаас буухдаа уулчны олс ашиглах;
 - 41.6. Тухайн давах саад нь бие даан хөдөлгөөн үйлдэх боломжгүй тохиолдолд хоёр, гурваараа нэг нэгийгээ хамгаалах;

42. Ууланд осолдогчийг хадтай хэсгээс нэрвэгдэгсдийн дамнуургаар тээвэрлэх;
43. Буулгалтын төхөөрөмж, хэрэгслийг хаданд бэхлэхдээ хамгаалалтын бэхэлгээг битүү дэгээгээр бэхлэх;
44. Цастай уулын налуугаар явахдаа хамгаалалтын нүдний шил, салхи үл нэвтрүүлэх хувцас, ханцуйвч, ган хадаас бэхэлсэн уулын гутал, муурын сарвуу хэлбэрийн хадаастай, уландаа бэхэлдэг уулын гутал өмсөх ба зөөлөн цасан дээр арзгар хээтэй гутал өмсөх;
45. Зөөлөн цастай газраар явахдаа гутлын улаар чирж явах;
46. Зөөлөн цастай, налуу газраар явахдаа гутлын улаар гадаргуу дээр цохилт өгч гутлынхаа улаар аажим гишгэж явах;
47. Хунгарласан цасан дээр гутлын ирмэгээр гишгэн цөмлөж, хэт хатуурч хөлдсөн хунгарыг мөс хагалагчаар хагалж ирмэг гаргах;
48. Хатуу хунгар дээр муурын сарвуу хэлбэрийн хадаасыг хэрэглэх;
49. Царцанги цасан дээр өлмийгөөр гишгэн цасыг нягтруулан явах;
50. Цастай уулын эгц налуу болон гүн сэвсгэр цастай газар уулын алхаар нүх гаргаж тулгуурын гурав дахь цэгийг бий болгож явах;
51. Буухдаа өмнөх аврагчийн гишгэсэн мөр дээр гишгэж явах;
52. Цасны нурангийн аюултай газарт мөстсөн цас хагарах, цасан нуранги үүсэхээс сэргийлж удаан хугацаагаар ташуулдаж явахаас зайлсхийх;
53. Цасан нурангийг анх харсан аврагч “Цасан нуранги дээрээс /зүүнээс, баруунаас/” гэж дохио өгөх;
54. Аврагчид “Цасан нуранги дээрээс /зүүнээс, баруунаас/” гэсэн дохиогоор урсгалын захад гарах, саад /хадан цохио, чулуу, мод ба бусад зүйлс/-ын ард нуугдаж, амьсгалаа боогдуулахгүйн тулд нүүрээ ноосон малгай, алчуураар халхлах;
55. Хэрвээ цасан нурангиас зугтах боломжгүй бол бүх ачаа /үүргэвч, цана гэх мэт/-г хаяж, цасан нурангийн урсгалын гадаргуу дээр гарах цасан нурангийн зах хязгаарт хүрэх ба түүний гадна талд гарах;
56. Эгц налуу бус газраар өгсөхдөө чанх дээшээ гутлынхаа дотор талын ирмэгээр цасыг цөмлөн “Гацуур” маягаар гишгэж өгсөх;
57. Цасан нурангийн аюулгүй, эгц өндөр ууланд “Зигзаг” хэлбэрээр авирах;
58. Цастай эгц налуу өөд муурын сарвуу, уулын алхыг ашиглан гутлынхаа өлмийгөөр цөмлөн авирах;
59. Цасан дээр хоёр хөлөөрөө баттай зогссоныхоо дараа уулчны алхыг дээшлүүлэн авирах;
60. Эгц бус налуу газраар уруудахдаа ойр ойрхон гишгэж, өсгийгөөрөө цас унаган, нуруугаа уулын налуу руу харуулан буух;
61. Эгц уулнаас буух нь өгсөхтэйгээ адилхан ба буцаах дэс дарааллаар явах;
62. Хатуу цасан хунгар ба мөстсөн уулан дээгүүр явахдаа муурын сарвуу хэлбэрийн хадаастай, уулын гутал хэрэглэн, хамгаалалтын холбоос ашиглах;
63. Мөсөн голын ангалаар явахдаа аврагч хоорондын хамгаалалтын бэхэлгээний /15-30 метр/ олсонд 2 метр тутам “Уулын эрвээхэй” зангилаа зангидах;
64. Эгц бус уулын налуу руу гулсах алхмаар буюу буухдаа ардаа уулчны алхны жадаар газар тулж буух;
65. 40 градусаас дээш эгц налуу руу хүнд үүргэвчтэй буухыг хориглоно;
66. 30 градус хүртэл налуутай мөсөн гадаргаар өгсөхдөө аврагчид өвстэй газраар явж байгаатай адилаар хөлийнхөө өлмийг гадагш эргүүлэн “Гацуур” хэлбэрээр гишгэж налуу өөд нүүрээ харуулж явах;
67. Мөсний гадаргуугаар явахдаа муурын сарвуутай гутлаараа зөөлөн цохиж шигтгэн “Зигзаг” хэлбэрээр явах;
68. 40 градусаас дээш налуутай эгц налуу руу өгсөхдөө муурын сарвууны урд хос хумсыг мөсөнд цохиж шигтгэн урд дөрвөн хумсан дээр явах;

69. Хөлийг өвдгөөр нь бага зэрэг нугалж, хөлийнхөө тавхайг тэгшхэн /уулчны алхыг мөсөн дээр шигтгэж/ гишгэж явах;
70. Огцом биш налуу руу буухдаа нуруугаа налуу руу харуулж уулчны алхыг ар буюу хажуудаа барьж үзүүрээр нь мөс рүү тулж буух;
80. Налуу огцом өгсөхөд уулчны алхаар гишгүүрийг /15-20 см зайтай/ ухаж явах;
81. Мөсөн хяр дээгүүр явахдаа шууд хяраар нь эсхүл арай бага налуутай газраар гишгүүр ухаж гарах;
82. Нэрвэгдэгсдийг өндөр уулын мөс эсхүл мөсөн хунгар, цасан нурангинаас буулгаж байгаа тохиолдолд буулгалтын төхөөрөмж, хэрэгслийг мөсний сүх, уулын алханд бэхлэж, цас, мөсийг ашиглаж хамгаалах бэхэлгээний цэг үүсгэж буулгах;
83. Нэрвэгдэгсдийг аврагчгүйгээр буулгаж байгаа тохиолдолд түүнд хөл, гараараа хадруу түлхэж хөндий буух зааврыг өгөх;
84. Цас, мөсөн нурангид хонгил гаргахын тулд малтлагын төхөөрөмжийг болон тусгай багаж хэрэгсэл, хийн шахуургын өргөх дэр, татагч ашиглах;
85. Нурангийн холилдсон хэсгүүдийг бэхжүүлэх, гаргасан хонгилынхоо амыг бөглөхдөө бэхэлгээний тусгай хэрэгсэл, тулгуур ашиглах;
86. Эрэн хайх, аврах ажиллагаанд ашигласан тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг ашигласны дараа шалгах;
87. Чулуу, шороо, цас, мөсөн нуранги доор байгаа нэрвэгдэгсдийг гар ажиллагаатай багаж ашиглан гаргах. Энэ үед цэвэр агаар нэвтрүүлэх арга хэмжээ авах, гаргасны дараа чиг боолт, чангалуурыг зааврын дагуу хийх.

---oOo---

АГУЙНААС ЭРЭН ХАЙХ, АВРАХ АЖИЛЛАГААНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР

1. Эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч /бүлгийн дарга/-ийн шийдвэрээр агуй руу орох нэг, хоёр, гурав, дөрөвдүгээр аврагчид хувийн болон бүлгийн багаж хэрэгслийг бэлтгэх;
2. Үндсэн, туслах олсыг хамгаалалтын бэхэлгээний цэгт бэхлэх;
3. Эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч /бүлгийн дарга/-ийн тушаалаар агуйн гүнийг тогтоох, мэдээлэл цуглуулах зорилгоор 2-оос доошгүй аврагчийг томилон ажлуулах;
4. Нэгдүгээр аврагч үндсэн олсоор буухдаа туслах олсоор хамгаалагдан доош бууж, агуйн болон /нэрвэгдэгсэд/ бусад мэдээллийг бүлгийн дарга, аврах ажиллагааны удирдагчид мэдэгдэх;
5. Мэдээлийн дагуу эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч /бүлгийн дарга/-ийн тушаалаар хоёрдугаар аврагчийг агуй руу оруулах;
6. Нэмэлтээр эсхүл сэлгэхээр гурав, дөрөвдүгээр аврагчийг агуй руу оруулах;
7. Агуйн нөхцөл байдлаас шалтгаалан ажиллах аврагчдын тоог тогтоох;
8. Аврах бүлэг, аврагчид агуй болон газар доор ажиллахад дараахнөлөөлөл, хүчин зүйлсийг тооцох. Үүнд:
 - 8.1. Агуйн нуралт болон чулуу унах, нуралт үүсэх;
 - 8.2. Байгалийн болон хиймэл найдваргүй баганууд нурах;
 - 8.3. Үелсэн шохойн агуйд нуранги үүсэх;
 - 8.4. Агуй руу орох хэсгийн 30 хувиас илүү нь шаварлаг байх;
 - 8.5. Аюултай амьтан буюу хортон шавьж байх;
 - 8.6. Усанд автах;
 - 8.7. Хүйтэн;
 - 8.8. Харанхуй;
 - 8.9. Агуйн утаа;
 - 8.10. Төөрөх;
 - 8.11. Агуйд хортой бодис их хэмжээгээр хадгалагдаж салхи бага нэвтэрдэг хажуугийн тасалгаа, булан тохойд хуримтлагдах.
9. Агуйн хийг шүдэнзний дөлний байдлаар тодорхойлох. Үүнд:
 - 9.1. Нүүрс хүчлийн хий байгаа тохиолдолд шүдэнзний гал унтрах;
 - 9.2. Нүүрс устөрөгч байгаа бол хүчтэй тортог үүсэх;
 - 9.3. Метан байгаа бол ер бусын тод асах;
 - 9.4. Шүдэнз асахгүй байгаа агуйд хошуувч болон амьсгалын шүүгч багашиглах;
 - 9.5. Нүүрс устөрөгч болон метан байгаа тохиололд гал болон тэсрэх аюулаас хамгаалах.
10. Радон болон түүний дагалдах бодисууд агаарт байгаа найрлагын хэмжээг тодорхойлогч зөөврийн илрүүлэгч хэмжигчийг ашиглах;
11. Радоны онц аюултай хийнээс хамгаалах чадвартай хошуувч, амьсгалын шүүгч баг ашиглах;
12. Радон хийтэй агуйд аврагчдыг богиносгосон цагаар ажиллуулах;
13. Багаж хэрэгсэлтэй холбоотой аюул. Үүнд:
 - 13.1. Карбид ламп дэлбэрэх;
 - 13.2. Битүүмжлэлгүй импульсийн лампын гүйдэлд цохиулах;

- 13.3. Усанд шумбах хэрэгслийн шахсан агаартай бортого дэлбэрэх;
 13.4. Эвдрэлтэй тоног төхөөрөмж хэрэглэх;
 13.5. Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл хүрэлцээгүй үед ажил явуулах эсхүл түүнийг зориулалтын бусаар ашиглах.
 14. Нарийн хонгил гатлах үед тэдгээрт гацах;
 15. Хүний хараа, ой ухаан муудах, бие махбодь өөрийгөө хамгаалах чадвар алдагдах, хий юм үзэх, сонсох;
 16. Агуй руу орох хэсэгт нүх байвал ёроол руу нь чулуу шидэж түүний унаж байгаа хугацааг секунд хэмжигчээр хэмжих замаар хамгийн түрүүнд түүний гүнийг хэмжих;
 17. Агуйд байгаа хүмүүст гэмтэл учруулахгүйн тулд жижгэвтэр чулуу сонгох;
 18. Чулуугаа шидэхдээ нүхэнд харагдахуйцаар хана руу цохиж хана нураах буюу чулуу унахаас сэргийлэх;
 19. Чулууны тусламжтайгаар ангалын /агуйн/ гүнийг тогтоох:

Хүснэгт 1.

Ажиглагдсан уналтын хугацаа	1 сек	2 сек	3 сек	4 сек	5 сек	6 сек	7 сек	8 сек
Агаар дахь дуу, чимээний хурдыг тооцсон чөлөөт уналтын гүн	4м	18м	40м	60м	85м	112м	142м	170м

20. Өндөр эрсдэл, хүндрэлтэй агуйнд нэрвэгдэгсдийг аюулгүй тээвэрлэхэд зориулсан тусгай маршрутыг бэлтгэх, нэрвэгдэгсдийг зөөвөрлөж аваачих, газар доорх баазыг байгуулах;
 21. Бүх нэрвэгдэгсдийг хүйтнээс хамгаалахын тулд дулаан хөнжлөөр хучих, халуун бүлээн цай, ус уулгах;
 22. Агуйн био энергийн орчин нь хүний биед хортойг анхаарах;
 23. Нэрвэгдэгсдэд анхны тусламж үзүүлэхийн зэрэгцээгээр агуйн аль нэг хэсгийг нэрвэгдэгсдийг тээвэрлэхэд зориулан бэлтгэх;
 24. Аюултай хэсгүүдийг шалгаж үзэн хэсэг бүр дээр тээвэрлэлт хийх хамгийн оновчтой зам /агуйн нарийн хавцал, оролтууд болон худаг, “Лонх”-оор гарах гэх мэт/-ыг олж тогтоох;
 25. Үер болсон тохиолдолд илүү аюултай хэсгүүдийг тэмдэглэх;
 26. Түр амрах болон байрлахдаа хамгийн тохиромжтой бүх хэсгүүдийг тэмдэглэх;
 27. “Газар-агуй” гэсэн утсан холбооны шугам тавих;
 28. Агуйн тэгш болон налуу хэсгүүдээр нэрвэгдэгсдийг тээвэрлэхдээ тэвш буюу торхон дамнуурга ашиглах;
 29. Огцом налуу хэсгээр нэрвэгдэгсдийг тээвэрлэхдээ аврагчид нь доод талаар хамгаалж явах;
 30. Нэрвэгдэгсдийг худаг болон уурхайгаас гаргах үед аврах ажиллагааны технологи газар дээрхтэй адил байх;
 31. Агуйд усны осол гарсан тохиолдолд усны гүнд шумбах иж бүрдэл, хэрэгсэл, ашиглах;
 32. Олон давхар таславчтай агуйд эрэн хайх, аврах ажиллагааг дараах хэлбэрээр зохион байгуулах. Үүнд:
 32.1. Үлдээсэн ул мөрөөр;
 32.2. Боломжтой тохиолдолд эрэлч нохой ашиглах;
 32.3. Шөнийн харааны болон дуу чимээ сонсох хайгуулын хэрэгсэл ашиглах;


32.4. Агуй, уурхай, худаг, агуйн давхруудыг эрэн хайх, аврах бүлэг, хэсгүүдэд хуваарилах;

32.5. Шаардлагатай тохиолдолд аюулын зэргээс үл хамааран нэг бүлгийн наврагчид агуйн бүх хэсгийг шалгах “Чөлөөт” хайлтаар хайх үед бэлтгэл бүлэг бэлэн байдалд байх;


33. Агуйнаас гаргасан нэрвэгдэгсдийг эмнэлгийн байгууллагад нэг, хоёр, гуравдугаар шатлалаар тээвэрлэх ажиллагааг зохион байгуулах.

---oOo---


АГААР /НИСДЭГ ТЭРЭГ, НИСЭХ ТӨХӨӨРӨМЖ/-ААС
ЭРЭН ХАЙХ ЗАГВАР




Зураг 1. Квадратын талбайн эрэн хайх нислэг




Зураг 2. Квадратын талбайг өсгөх эрэн хайх нислэг




Зураг 3. Агаарын хөлгийн замын дагуух “Эргэлттэй” эрэн хайх нислэг




Зураг 4. Агаарын хөлгийн зам дагуух “Эргэлтгүй” эрэн хайх нислэг



Зураг 5. “Зэрэгцээ хэлбэр”-ийн эрэн хайх нислэг



Зураг 9. “Ил харааны хэсэгчилсэн” эрэн хайх нислэг



Зураг 10. “Тойрох, бүслүүрдэх, чөлөөт, контур”-ын эрэн хайх нислэг

---oOo---

АВРАХ ОЛСНЫ БҮРТГЭЛ, АШИГЛАЛТЫН ЗАГВАР

1. Аврах олс:

Аврах олсны бүтэц	Аврах олсны ангилал	Аврах олсны уртын хэмжээ	Аврах олсны диаметр	Өнгө, хээ	Зориулалт /аврах, спорт/
Кернмантел	Динамик	30, 50, 60, 100, 200 м	11-13 мм		
Кернмантел	Статик /суналт 6% аас бага/	30, 50, 60, 100, 200 м	11-13 мм		
Кернмантел	Статик /суналт 6-10%/	30, 50, 60, 100, 200 м	11-13 мм		

2. Аврах олсны бүртгэл:

Олсны дугаар №		Үйлдвэрлэгч:	Үйлдвэрийн серийн дугаар:
		Урт:	Үйлдвэрлэсэн огноо:
Олсны зориулалт /аврах, спорт, сонирхогч/:		Диаметр:	Худалдаж авсан огноо:
		Ангилал /статик, динамик, кевлар/:	Баталгаажуулсан огноо:
		Төрөл /дан, давхар, хос/:	Ашиглалтад авсан огноо:

3. Аврах олсны ашиглалт:

№	Олсны дугаар	Олсны ангилал	Олсны урт/ диаметр	Өнгө, хээ	Ашиглалтын өмнөхүлээлгэн өгсөн огноо	Аврах олс ашиглалтын өмнөх		Ашиглалтын байдал /аврах, дадлага, сургууль/	Ашиглалтын дараах хүлээлгэн өгсөн огноо	Аврах олс ашиглалтын дараах		Тайлбар, санал
						Хүлээл -гэн өгсөн	Хүлээн авсан			Хүлээл -гэн өгсөн	Хүлээн авсан	

4. Аврах олсны ашиглалт:

Огт ашиглагдаагүй бол	10 жил
Жилд 2 удаа ашигласан бол	7 жил
Сард 1 удаа ашигласан бол	5 жил
Сард 2 удаа ашигласан бол	3 жил
Сард 4 удаа ашигласан бол	2 жил
Өдөр тутам ашигласан бол	1 жил хүртэл


---oOo---

АВРАХ ОЛСНЫ ЗАНГИЛААНЫ ЗАГВАР


1. Аврах олсны зангилаа:




Зураг. 1. “Узүрийн 8” зангилаа




Зураг. 2. “Хөөх 8” зангилаа




Зураг. 3. “Гогцоо” зангилаа




Зураг. 4. “Уулын эрхвээхэй” зангилаа




Зураг. 5. “Тугалчлах буюу UIAA” зангилаа




Зураг. 6. “Уулын тооно тушаа” зангилаа



Зураг. 7. “Уулын тооно тушаа” зангилаа




Зураг. 8. “Загасчны давхар” зангилаа




Зураг. 9. “Олс холбох загасчны давхар” зангилаа




Зураг. 10. “Олс холбох” зангилаа




Зураг. 11. “Мюнтер” зангилаа




Зураг. 12. “Прусик” зангилаа




Зураг. 13. “Автоблок” зангилаа




Зураг. 14. “Хонин холбоо” зангилаа



Зураг. 15. “Давхар мюнтер” зангилаа




Зураг. 16. “Мюнтер-мюл” зангилаа




Зураг. 17. “Давхар мюнтер-мюл” зангилаа



Зураг. 18. “Гарда” зангилаа



Зураг. 19. “Бэхэлгээний” зангилаа




Зураг. 20. “Түгжих” зангилаа




Зураг. 21. “Хамгаалах олсны” зангилаа


2. Аврах олсны зангилааны техник:




Зураг. 22. “Хамгаалах хэрэгслийн түгжих-мюл” техник



Зураг. 23. “Аврагч ачааллыг бэхэлгээний цэгт шилжүүлэх” техник



Зураг. 24. “Аврагч ачааллыг бэхэлгээний цэгт шилжүүлэх” 1-р хувилбар.




Зураг. 25. “Аврагч ачааллыг бэхэлгээний цэгт шилжүүлэх” 2-р хувилбар.

3. Нэрвэгдэгсдийг буулгах үеийн техник:



Зураг. 26. “Нэрвэгдэгсдийг дангаар нь буулгах” техник




Зураг. 27. “Нэрвэгдэгсдийг буулгах үеийн олсны залгаас дамжуулах” техник




Зураг. 28. “Аврагч нэрвэгдэгсдийг өөртөө бэхлэх” техник



Зураг. 29. “Аврагч нэрвэгдэгсдийг авч буух” техник



Зураг. 30. “Аврагч нэrvэгдэгсдийг буулгах үеийн олсны залгаас дамжих” техник




Зураг. 31. “Тандем-буулгах” техник


4. Нэрвэгдээсдийг татах үеийн техник:



Зураг. 32. “Татах үед олс алдахаас хамгаалах” техник



Зураг. 33. “3:1” техник



Зураг. 34. “5:1” техник



Зураг. 35. “7:1” техник

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
 2019 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
 дугаар тушаалын долоодугаар хавсралт

3:1, 5:1, 7:1 ТАТАХ СИСТЕМИЙГ ТООЦОХ ЗАГВАР

2:1 Татах системийн үр ашгийн тооцоо		
0.25 хувь карабинд, 1 хувь дамарт		
	1	Үр ашиг
Карабин	2.19	1.21
Дамар	1.37	1.53

3:1 Татах системийн үр ашгийн тооцоо			
0.25 хувь карабинд, 1 хувь дамарт			
	1	2	Үр ашиг
Карабин	2.19	2.19	1.55
Дамар	1.37	1.37	2.12
д,к	1.37	2.19	1.7
к,д	2.19	1.37	1.88

5:1 Татах ситемийн үр ашгийн тооцоо				
0.25 хувь карабинд, 1 хувь дамарт				
	1	2	3	Үр ашиг
Карабин	2.19	2.19	2.19	2.33
Дамар	1.05	1.05	1.05	4.72
д,к,к	1.05	2.19	2.19	3.28
к,д,к	2.19	1.05	2.19	2.56
к,к,д	2.19	2.19	1.05	3.05
д,д,к	1.05	1.05	2.19	3.75
к,д,д	2.19	1.05	1.05	3.28
д,к,д	1.05	2.19	1.05	4.25

Жич: анхан шатны татах 3:1, 5:1, 7:1-ийн системийг үндэслэн 9:1, 11:1 гэх мэт татах системийг угсарах.

---oOo---

АВРАХ ОЛСНЫ ЗАНГИЛААНЫ ДААЦЫГ ТООЦОХ ЗАГВАР

Зангилаа	Зангилааны онцлог ба хэрэглээ	Дундаж даац
8 тоо	10 мм-ийн давхцаж зөрөлдөөгүй олсны уртаашаа авах даац	17 кN хүртэл
	10 мм-ийн давхцаж зөрөлдсөн олсны уртаашаа авах даац	13 кN
	10 мм-ийн гогцоо зангилаанд	5 кN
2 олсыг холбоход	10 мм-ийн олс	7 кN
3 ороосон Прусик зангилаа	10 мм олсонд 7 мм дээсээр орооход	Даац ойролцоогоор 7 кN
Клемхайст зангилаа	10 мм олсонд 7 мм дээсээр орооход	9 кN хүртэл
10 мм олсоор тугалчлах зангилаа	-	Даац ойролцоогоор 9 кN
Уулын тооно тушаа	10 мм-ийн даацын олсонд	15 кN хүртэл
	10 мм-ийн олсны хамгаалах зангилгаагүй үеийн ачаалал даах дээд хэмжээ	1 кN хүртэл
	10 мм-ийн олсны хамгаалах зангилаатай үеийн ачаалал даах дээд хэмжээ	6 кN хүртэл
Тугалчлах буюу UIAA зангилаа	-	Хамгаалагч дээр ирэх ачааллыг карабин болон олсноос хамаарч 7-12 дахин бууруулна.

---oOo---

АВРАГЧ-УУЛЧНЫ ТОНОГЛОЛЫН ДААЦЫГ ТООЦОХ ЗАГВАР

Тоноглол	Ажлын даац	Тайлбар
Хадны гадас, хэвтээ	5-25 кN	Даац нь гадасны хийц, материал, чанараас хамаарна
Хадны гадас, босоо	3-15 кN	
Тэлдэг жижиг гацаа	3-8 кN	Даац нь гацааны чанар болон хаданд зөв суулгасан эсэхээс хамаарна
Тэлдэг дунд гацаа	5-10 кN	
Тэлдэг том гацаа	8-20 кN	
Энгийн жижиг гацаа	2-6 кN	
Энгийн дунд гацаа	5-10 кN	
Энгийн том гацаа	8-12 кN	
АТС тоног автоматаар тормослох горим дээр	4-6 кN	Карабин, олсноос хамаарна
Мөсний сүх /15-22 см/	10-20 кN	Тогтвортой ачаалал нь мөсний чанар, түүний температур, орчны температур, түүнчлэн угсралтын чанараас хамаарна.
Мөсний сүхийг босоогоор нь хөлдсөн сул цасанд зооход	1кN-с бага	-
Мөсний сүхийг босоогоор нь нягт, нойтон цасанд зооход	1.5-2 кN	-
Хүрз нягт цасанд	3-4 кN	-
Карабин	6-22 кN	Авах чиглэл, түгжээтэй түгжээгүйгээс хамаарна
Зажим /жумар/	4 кN даацын 10 мм-ийн олсны бүрээс гэмтээнэ	Даац 6-7 кN олсыг таслах магадлалтай
Цээжний хударга	10 кN	-
Доод хударга	15 кN	Даац 15 кN хударганы даацын гогцоо нь
Ролик	12 кN	Даац 6 кN
Нэг чигтээ зогсоох тоног	4-5 кN	8-11 мм-ийн олсонд хэрэглэнэ
Туузан цагариг	15-20 кN	-
6 мм-ийн нарийн дээс	7.2 кN	-
7 мм-ийн нарийн дээс	9 кN	-
8 мм-ийн нарийн дээс	12 кN	-
Хаданд суулгадаг гогцоо	22 кN	12 мм-ийн даац нь зөв суулгасан эсэхээс шалтгаална
Цавууддаг хадны гогцоо	36 кN хүртэл	-
Цохиж суулгадаг хадны гогцоо	15-22 кN	-

---оОо---

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2019 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар тушаалын аравдугаар хавсралт

УУЛЫН ӨВЧНИЙ ИЛРЭХ ШИНЖ БАЙДАЛ,
АНХНЫ ТУСЛАМЖИЙН ЗЭРГИЙГ ТООЦОХ ЗАГВАР

Үндсэн ажиглалт,ерөнхий оношлогоо	Зэрэг	Хээрийн нөхцөл дээрх боломжит эмчилгээ
<ul style="list-style-type: none">- Толгой өвдөх;- Өтгөн хаталт, хоолны дуршил буурах;- Нойргүйдэл- Толгой эргэх.	Хөнгөн	Амрах
<ul style="list-style-type: none">- Толгой өвдөх;- Бөөлжих;- Хямралд орох;- Суулгах.	Дунд	Амрах болон өндөрт авирахыг зогсоох
<ul style="list-style-type: none">- Толгой өвдөх;- Бөөлжих;- Амрах үед амьсгалахад хүндрэлтэй байх;- Маш хүчтэй ядрах;- Гүйлгэх	Хүнд	Өндөр уулнаас буулгах, хүчилтөрөгчийн баг ашиглах

---oOo---

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2019 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
.... дугаар тушаалын арваннэгдүгээр хавсралт

АВРАГЧ-УУЛЧНЫ МЭРГЭЖЛИЙН ҮНЭМЛЭХНИЙ ЗАГВАР



А.Хавтас /гадна/

Зураг 3x4	Үнэмлэхний дугаар				
	Овог				
	Нэр				
	Регистрийн дугаар :				
	Үндсэн захиргаа:				
	Төрсөн огноо :				
Сургалт	зохион	байгуулласан	газар,	хугацаа:	
.....	
.....	
.....	
Суралцсан	газар,	уулын	нэр,	өндөр,	зам:
.....
.....
АВРАГЧ-УУЛЧИН мэргэжлийг олгосон сургалтын ажлын хэсэг:					
Дарга					
Гишүүд					
/Цол/ гарын үсэг /нэр/					
					Тамга огноо

Б. 1 дүгээр хуудас

**АВРАГЧ-УУЛЧНЫ МЭРГЭЖЛИЙН.....-Р ЗЭРГИЙН
СУРГАЛТ**

Өндөр уулнаас эрэн хайх, аврах ажиллагааны сургалт зохион байгуулагдсан газар:

.....
.....

Уулын нэр, өндөр, замын ангилал:

Хадаар авирсан

Мөсөөр авирсан.....

Цасаар авирсан.....

Агуйнаас эрэн хайх, аврах ажиллагаа

Олсонд ажиллах техник, бэхэлгээ тавих.....

Уулын авиралтын арга техникийн онолын мэдлэг.....

АВРАГЧ-УУЛЧНЫ –р зэрэг олгосон сургалтын ажлын хэсэг:

Дарга

Гишүүд

/Цол/ гарын үсэг /нэр/

Тамга

огноо

В.2 дугаар хуудас

Тодотгол: Эх бичигд эвтэрт 5 удаа давтагдах ёстой.

**АВРАГЧ-УУЛЧНЫ МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ДАДЛАГАД ОРОЛЦСОН
БАЙДАЛ**

Дэс дугаар	Газар, уулын нэр	Уулын өндөр	Замын ангилал	Огноо	Зааварлагчийн гарын үсэг

Өндөр уулнаас эрэн хайх, аврах ажиллагааны мэргэжилтэн:

/...../...../...../

/цол/

/гарын үсэг/

/нэр/

Г.6 дугаар хуудас

Тодотгол: Эх бичиг дэвтэрт 10 удаа давтагдах ёстой.

АВРАГЧ-ЭМНЭЛГИЙН ЗААВАРЛАГЧИЙН ЗААВАРЧИЛГАА

Дэс дугаар	Огноо	Зааварчилгаа авсан газар	Зааварчилгаа өгсөн эмнэлгийн зааварлагчийн гарын үсэг

Ё.36 дугаар хуудас

Тодотгол: Эх бичиг дэвтэрт 10 удаа давтагдах ёстой.

Тодотгол. Үнэмлэхний хэмжээ 170 мм х 110мм

---oOo---

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2019 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
.... дугаар тушаалын арванхоёрдугаар хавсралт

АВРАГЧ-УУЛЧНЫ НЭГДСЭН БҮРТГЭЛИЙН ЗАГВАР

№	Харьяа, анги, байгууллага, албан тушаал	Овог	Нэр	Цол	Төрсөн он, сар өдөр	Ажилла- сан жил		Аврагч-уулчны сургалтад хамрагдсан байдал				Өндөр уулнаас эрэн хайх, аврах ажиллагаанд оролцсон байдал /ажиллагаа тус бүрээр он, сар, өдрөөр бичих/ Аврагч-уулчны зэрэг болон уулын спортын зэрэг /шийдвэрийн дугаар огноо/	
						Улсад	ОББ-д	Дотоод		Гадаад			
								Сургалт /дэлгэрэнгүй огноо, хугацаатай бичих/	Дадлага /дэлгэрэнгүй огноо, хугацаатай бичих/	Сургалт /дэлгэрэнгүй огноо, хугацаатай бичих/	Дадлага /дэлгэрэнгүй огноо, хугацаатай бичих/		
1													
2													

Жич:

- Дотоод, гадаадын сургалт хэсэгт өндөр уулнаас эрэн хайх, аврах ажиллагааны ямар мэдлэг, ур чадварыг сургалтаар эзэмшсэнийг бичнэ.

- Дотоод гадаадын дадлага хэсэгт сургалтаар олсон мэдлэг, ур чадвараа бататган дадлагажуулсаныг бичнэ.

---оОо---